

БАТЛАВ:
“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ”
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ:
“.....” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.ГАНХУЯГ

.....

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20.... оны сарын.....өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв хаягт байрлах, регистрийн дугаартай “Эрдэнэс-Тавантолгой” ХК (цаашид “Захиалагч” гэх), түүнийг төлөөлж, нөгөө талаас хаягт байрлах, регистрийн дугаартай.....хаягт байрлах “.....” ХХК (цаашид “Нийлүүлэгч” гэх) түүнийг төлөөлж нар (цаашид хамтад нь “талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолт (гэрээний хавсралт №3)-д заасан шаардлага хангасан/цаашид “Бараа” гэх/-ийг нийлүүлэх, Захиалагч нь гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Энэхүү гэрээ нь байгуулагдсан өдрөөс хойш хоногийн хугацаатай байна.

2.2. Нийлүүлэгч нь гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж, доголдолгүй барааг Захиалагчид хүлээлгэн өгч бараа хүлээлцсэн болон гэрээ дүгнэх акт үйлдсэнээр гэрээний үүрэг дуусгавар болно.

2.3. Гэрээг талууд харилцан тохиролцож хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

2.4. Барааны баталгаат хугацаа жил байх ба энэ хугацааг барааг Захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн тоолно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1. Гэрээний үнэ буюу нийт төлбөртөгрөг байх бөгөөд гэрээний хугацаанд барааны нэгж үнэ өөрчлөгдөхгүй. Энэ үнэд НӨАТ бусад татвар, хураамж, барааг тээвэрлэх, хүргэх, шалгах зэрэг бүх зардал багтсан болно.

3.2. Захиалагч гэрээнд заасан шаардлага хангасан барааг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш хоногийн дотор хүлээж авсан барааны төлбөрийг Нийлүүлэгчийн банкны тоот дансанд шилжүүлнэ.

3.3. Гүйцэтгэгчид төлөх төлбөр нь гэрээний 3.1-д заасан гэрээний үнийн дүнд заавал хүрсэн байхыг шаардахгүй

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь Нийлүүлэгчээс барааг техникийн тодорхойлолт (гэрээний хавсралт №3)-д заасны дагуу гэрээний үнийн дүнд багтаан, Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхийг шаардах эрхтэй.

4.2. Захиалагч нь нийлүүлэгчээс гэрээний 1.1-д заасан шаардлагыг хангасан барааг хүлээн авч, бараа хүлээлцсэн акт үйлдэнэ.

4.3. Захиалагч Нийлүүлэгчийн барааны чанарыг техникийн тодорхойлолт (гэрээний хавсралт №3)-ыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор шалган туршиж хүлээн авах эрхтэй ба шаардлага хангаагүй эсхүл ирүүлсэн дээж бараанаас чанар стандартын хувьд өөр барааг шинээр солиулах, шаардлагад нийцүүлэн нийлүүлэхийг шаардах эрхтэй.

4.4. Захиалагч барааг техникийн тодорхойлолт (гэрээний хавсралт №3)-д заасан шаардлага хангахгүй бол хүлээн авахгүй байх ба улмаар гэрээг цуцлах, төлбөрийг төлөхгүй байх эрхтэй.

4.5. Бараатай холбоотой санал, гомдол гарах, доголдол илэрвэл түүнийг шинээр солиулах, захиалагчид учирсан хохирол, гарсан зардлыг Нийлүүлэгчээр нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

4.6. Барааны баталгаат хугацаанд Захиалагч барааны доголдлыг Гүйцэтгэгчээр арилгуулах, доголдолтой барааг шинээр солиулах эрхтэй.

4.7 Хууль тогтоомжид заасны дагуу гомдлын шаардлага гаргах эрхтэй.

4.8 Захиалагчийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан барааны үйлдвэрлэлийн явцтай танилцах, санал, шаардлагаа тавих эрхтэй.

4.9 Захиалагч барааны тоо, хэмжээг 20 хүртэл хувиар бууруулж, нэмэгдүүлж болох бөгөөд энэ талаар Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэнэ

ТАВ. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Нийлүүлэгч гэрээнд заасан чанар, стандартын шаардлагад нийцсэн, тоо хэмжээ, эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй, техникийн тодорхойлолт (гэрээний хавсралт №3)-д заасан шаардлага хангасан барааг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд нийлүүлнэ.

5.2. Нийлүүлэгч нь Барааг гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор Захиалагчид нийлүүлэх үүрэгтэй.

5.3. Нийлүүлэгч нь захиалагчтай хамтран гэрээний 1.1-д заасан шаардлагыг хангасан барааг нийлүүлж, бараа хүлээлцсэн акт үйлдэнэ.

5.4. Нийлүүлсэн бараанд илэрсэн барааны үйлдвэрийн болон нийлүүлэгчээс шалтгаалсан аливаа доголдлыг өөрийн санаачилгаар болон Захиалагчийн анхны шаардлагаар 3 (гурав) хоногийн дотор арилгаж шинээр дахин нийлүүлэх арга хэмжээ авна.

5.5. . Нийлүүлэгчээс бараанд олгох баталгаат хугацаа 1 жил байна. Баталгаат засварын хугацаанд бараанд илэрсэн аливаа гэмтэл доголдол (эвдэрч, гэмтэх, урагдаж, ханзрах, угаахад агшиж сунах, өнгөө алдах зэрэг) илэрвэл шинээр сольж өгөх үүрэгтэй.

5.6. Нийлүүлэгч гэрээ байгуулснаас хойш гэрээгээр хүлээсэн үүргээс татгалзах эрхгүй. Хэрэв Нийлүүлэгч дур мэдэн гэрээнээс татгалзах бол үүнтэй холбогдон Захиалагчид учирсан шууд болон шууд бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

5.7. Барааг захиалагчид хүлээлгэж өгөхөөс өмнөх хугацааны бараатай холбоотой бүхий л эрсдэлийг Нийлүүлэгч хариуцаж, эрсдэлийг даатгуулсан байна.

5.8. Захиалагчийн хүсэлт, шаардлагын дагуу барааны загвар, өнгө, размер, логод өөрчлөлт оруулах үүрэгтэй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэхдээ гэрээнд заасан хугацааг хэтрүүлж нийлүүлсэн бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алданги төлнө.

6.2. Нийлүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй гэж Захиалагч үзвэл төлбөрийг шилжүүлэхгүй байх эрхтэй бөгөөд улмаар Захиалагч нэг талын санаачилгаар гэрээг цуцалж, өөрт учирсан хохирлоо Нийлүүлэгчээс шаардана.

6.3. Энэхүү гэрээг зөрчсөний улмаас үүссэн аливаа хохирлыг Нийлүүлэгч бүрэн хариуцаж, үл маргах журмаар Захиалагчид нөхөн төлнө.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдож болно.

7.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн долоо хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.

7.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ,

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

8.1. Талууд харилцан тохиролцсоноор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын гарын үсгээр баталгаажуулж, гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

8.2. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс шийдвэрлэж чадвал Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД

9.1. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

9.2. Гэрээг 3 (гурав) хувь үйлдэж, талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

9.3. Доорх хавсралтууд нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.

9.3.1. Хавсралт №1 Гэрээний ерөнхий нөхцөл;

9.3.2. Хавсралт №2 Гэрээний тусгай нөхцөл;

9.3.3. Хавсралт №3 Техникийн тодорхойлолт;

9.3.4. Хавсралт №4 Барааны жагсаалт ба Бараа нийлүүлэлтийн хуваарь;

9.3.5. Хавсралт №5 Барааны үнийн хуваарь.

9.4. Гэрээний зохицуулалт ба түүний хавсралтууд хоорондоо зөрчилдвөл гэрээний заалтыг баримтална.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН

.....

.....

Хаяг: Финанс төв, Жигжиджав-8

Чингэлтэй дүүрэг, 1-р хороо

Улаанбаатар хот – 15160,

Утас: 75055555

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....” ХХК-ИЙН

.....

.....

Хаяг:

.....